

**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИЙН БАЙР  
ЗАСВАРЛАХ, ХАЛААЛТЫН ШУГАМ ТАТАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендерийн нэр: “Говийн бүсийн салбарын туршилтын лабораторийн байр  
засварлах, халаалтын шугам татах ”**

**Тендерийн дугаар: ЦДҮС/20201019**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.30

**“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Говийн бүсийн салбар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Говийн бүсийн салбарын туршилтын лабораторийн байр засварлах, халаалтын шугам татах” ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30.000 /гучин мянга / төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 04 дугаар сарын өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Дундговь аймаг Сайнцагаан сум “ЦДҮС” ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын төв байр, 2-давхар 205б тоотод 2020 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн 10.10 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг  
“ЦДҮС” ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын төв байр, 2 давхар, 205б тоот

Захиргаа аж ахуйн алба  
Утас: 88871788, 99077965

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.   |
|   | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | 3.1. | Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | 4.1. | Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.  |
|   | 4.2. | Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.   |
|   | 4.3. | Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.  |
|   | 4.4. | Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.  |
| <b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | 5.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна.
- (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ.
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна.
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн нэг жилийн буюу 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Сүүлийн хоёр жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ / нотариатаар баталгаажуулна/</li> <li>- Татварын цахим тодорхойлолт</li> <li>- Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</li> <li>- Санал болгож буй үнийн дүнгээс багагүй өртөгтэй ижил төстэй ажил 2018,2019 онд гүйцэтгэсэн байх. / гэрээ, актуудыг хавсаргах /</li> <li>- Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын талаарх ашиглагч байгууллагын тодорхойлолт / сүүлийн 2 жилийн байдлаар /</li> <li>- Шүүхийн байгууллагын тодорхойлолт</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>- Авах боломжтой зээлийн нийт дүн: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй.</li> <li>- Борлуулалтын хэмжээ: 2017,2018 оны борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. Байгууллагын тодорхойлолт нь тендер зарласан өдрөөс хойш байна.</li> </ul> <p>Уг ажлыг гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр доорх тусгай зөвшөөрөл шаардлагатай.</p> <p>Барилга хот байгуулалтын яамны:</p> <ul style="list-style-type: none"> <li>- БА-8.1 Барилга байгууламжийн засвар , засал чимэглэл, интерьер, орчны тохижилтийн ажил.</li> </ul> <p>Гэрээг гүйцэтгэхэд дараахь мэргэжилтэй ажилчид шаардлагатай бөгөөд үндсэн ажилтан байна. Нэг ажлын байранд нэг хүн санал болгоно. / Сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын тооцооны хуудас, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, дипломын хуулбарыг хавсаргана. Үүнд: <b>Барилгын инженер</b></p> <p><b>Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны инженер</b></p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд ( өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м ) бэлэн байлгах шаардлагатай.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ачааны автомашин</li> </ol> <p>Тендерт оролцогч нь үнэлэгдсэн үе шатны хуваарь / төсөв/ бэлтгэхдээ</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын даалгавар, ажлын тоо хэмжээтэй уялдуулан тооцсон төсөвтэй, баталгаажуулсан байна.</li> <li>- Ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг баталгаажуулан гаргасан байна.</li> <li>- Магадлашгүй ажлын зардал, захиалагчийн хяналтын зардлыг төсөв зохиох зааврын дагуу тооцно.</li> </ul> <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д өөрийн аж ахуй нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: <b>Тендерийг 2020 оны 04 дугаар сарын 10 -ны</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>

<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Дундговь аймаг Сайнцагаан сум “ЦДҮС” ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын төв байр</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар: 2-р давхар 2056</p> <p>Огноо: <b>2020 оны 04 дугаар сарын 10-ны</b></p> <p>Цаг: <b>10 цаг 10 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ:</p> <p><b>“Говийн бүсийн салбарын туршилтын лабораторийн байр засварлах, халаалтын шугам татах”</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

БАТЛАВ  
 “ЦДҮС” ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ  
 ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.ДАШДАВАА

### Говийн бүсийн салбарын туршилтын байрны засварын ажлын даалгавар

1. Дээврийн буулгах, дотор байгаа савыг гаргах / Автокран ашиглах/
2. Сэндвич хавтангаар дээвэр хийх
3. Барилгын газардуулах байгууламжийг хийх
4. Дотор ханыг шавардах, өнгөлгөө замаска татах, эмульс, тосон будагаар будах
5. Шал цутгах, гантиг чулуу наах
6. Дүүжин тааз хийх
7. Гадна ханыг нягт өндөртэй галд тэсвэртэй хөөсөнцөрөөр дулаалж өнгөлгөө хийх.
8. 2 ширхэг бүргэд хаалга суулгах
9. 2 ширхэг вакум цонх суулгах
10. Хаалга цонхонд амалгаа хийх
11. Хаалаалтын шугамын трасс ухах
12. Халаалтын шугам татах, дулаалах
13. Туршилтын байранд халаалт хийх
14. Дотор цахилгаан хангамж хийх

### Говийн бүсийн салбарын туршилтын байрны засварын ажлын даалгавар

№	Засвараар хийх ажил	Х/Н	Тоо ширхэг	Хэмжээ /м/	Тайлбар
1	Дээврийг буулгах, дотор байгаа савыг гаргах / Автокран ашиглах/ савны суурь авах	м2	80	8x10 хэмжээтэй	Дотор нь 5тн хэмжээтэй хөнгөн цагаан сав байгааг дээврээр нь гаргах
2	Сэндвич хавтангаар дээвэр хийх	м2		8x10 хэмжээтэй	Дээврийг 200 мм сэндвичээр дээвэрлэх
3	Барилгын газардуулга хүрээ хийх	м	56		Барилгын тойрсон газардуулга хүрээ полсвой
4	Барилгын газардуулга гадас хийх	ш	16	1,2-1,5м	
5	Дүүжин тааз хийх	м2	80	8x10 хэмжээтэй	Дотор нь дүүжин тааз хийх
6	Дотор ханыг шавардах өнгөлгөө замаска татах, эмульс, тосон будгаар будах	м2	126		
7	Шал цутгах, гантиг чулуун хавтан наах	м2	80		Шалыг тэгшилж гантиг чулуун хавтан наах
8	Гадна ханыг нягт өндөртэй галд тэсвэртэй	м2	116	8x10 хэмжээтэй	100мм зузаантай галд тэсвэртэй нягт өндөртэй хөөсөнцөр хавтан хийх



	хөөсөнцөрөөр дулаалж өнгөлгөө хийх.				
9	Бүргэд хаалга суулгах	ш	2	90x200 хэмжээтэй	
10	2 ширхэг вакум цонх суулгах	ш	2	120x180	
11	Хаалаалтын шугамын трасс ухах	м3	42		
12	Халаалтын шугам, цэвэр усны шугам татах, дулаалах	м	100		d=32мм ган шугам, d=25мм цайран шугамыг зориулалтын дулаалгаар дулаалж хийх
13	Туршилтын байранд халаалтын систем татах	Ком	1	8x10x3	Дотор халаалтын системийг объектын эзлэхүүнд тохируулж хийх
14	Дотор цахилгаан хангамж хийх	Ком	1		

Ажлын даалгавар хянасан: ГБС-ын Ерөнхий инженер  Б.Дамбийням

Ажлын даалгавар гаргасан: ГБС-ын ЗААА-ны дарга  Т.Мөнхбаяр

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |  |
|--|--|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                    | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг <b>ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэнэ.</b>   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                   | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                               | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                 | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                         | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**

- |                                  |   |
|----------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>         | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил гомдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гомдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.   |

- |   |   |
|---|---|
| <b>9. Зөрчил<br/>гологдол<br/>арилгах</b>         | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
|   | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гомдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.  |
| <b>10. Зөрчил, гомдол<br/>арилгахгүй<br/>байх</b> | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гомдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.                             |

### **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- |   |  |
|---|--|
| <b>11. Үе шатны<br/>ажлын хуваарь</b>                   | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.  |
|   | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шат ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.  |
| <b>12. Үе шатны<br/>ажлын<br/>хуваарийг<br/>өөрчлөх</b> | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.  |
| <b>13. Алданги</b>                                      | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

### **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- |                            |  |
|----------------------------|--|
| <b>14. Ажил дуусгах</b>    | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| <b>15. Хүлээж<br/>авах</b> | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.   |

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн илрүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг  
цуцалсан үед  
хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давтагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 2.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “ЦДҮС” Говийн бүсийн салбарын Туршилтын лабораторын байр засварлах, халаалтын шугам татах ажил. ЦДҮС/20201019
- ГЕН 2.1** Ажил нь “Говийн бүсийн салбарын туршилтын лабораторийн байр засварлах, халаалтын шугам татах”
- Ажлын талбай нь : “ЦДҮС”ТӨХК-ийн ГБС
- ГЕН 3.1** Төслийн менежер нь
- ГЕН 4.1** Зөвшөөрөл авч ажил эхэлсэн өдрөөр тооцогдоно.
- Ажил эхлэх өдөр 2020 оны ... дугаар сарын ... -ны өдөр
- Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацаа: Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хийж дуусгах
- ГЕН 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- ГЕН 9.1** Чанарын баталгаат хугацаа [1] жил байна.
- ГЕН 13.1** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05% байна.
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5% байна.
- ГЕН 17.1** Гүйцэтгэгчийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө.
- ГЕН 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0-иар тооцно.



## ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “ажил” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн нь \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: / аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/  
Улсын төсвөөс: 20... онд \_\_\_\_\_ төгрөг, 20... онд нь \_\_\_\_\_ төгрөг  
Орон нутгийн төсвөөс: 20... онд нь \_\_\_\_\_ төгрөг, 20... онд: нь \_\_\_\_\_ төгрөг,  
Өөрийн хөрөнгө: 20... онд нь \_\_\_\_\_ төгрөг, 20... онд нь \_\_\_\_\_ төгрөг.
4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 4.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 4.2. Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;
  - 4.3. Үнийн санал;
  - 4.4. Гэрээний тусгай нөхцөл;
  - 4.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 4.6. Техникийн тодорхойлолт
  - 4.7. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
  - 4.8. Зураг
  - 4.9. Санхүүжилтийн хуваарь.
  - 4.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
6. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Гүйцэтгэгчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*